



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

### Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 28,702,415,520.00 (хорин найман тэрбум долоон зуун хоёр сая дөрвөн зуун арван таван мянга таван зуун хорь) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн цогцолбор барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Нийслэл, Ховд, Архангай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Ховд, Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, Нийслэл, Ховд, Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын хөрөнгөд бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001445

15-r\_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 05 дүгээр сарын 09 нийгнэлийн өдрийн  
158 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ААР БАРИГДСАН,  
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт	
				Огноо	Дугаар
1	Эрүүл мэндийн төвийн барилга (Ховд аймаг, Дөргөн сум, Эрүүл мэндийн төвийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, бага ангилалын, зоорьгүй, 2 давхар 15 ортой, тэнхлэгээрээ 32.0м*16.3м барилга	1,329,101,930.00	2022.12.19	ББКД/69/2022
2	Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, БЗД-ийн ЭМТ-ийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд төлөвшилтэй ангилалын, 0.00 түвшинээс доош 1 давхар, 0.00 түвшинээс дээш 4 давхар, 13.0м*23.15м, 1 блок барилга	2,159,950,059.00	2024.03.12	БА-053/2024
3	Нэгдсэн эмнэлгийн барилга (Архангай аймаг, Эрдэнэбулган сум, өөрийн эзэмшлийн газар дээр)	300 ортой, хэвтэн эмчлүүлэх хэсэг А блок зоорь бүхий 5 давхар, тэнхлэгээрээ 76.7м*16.8м, Поликлиникийн хэсэг Б блок тэнхлэгээрээ 73.2м-16.4м зоорь бүхий 4 давхар, Халдвартын хэсэг В блок тэнхлэгээрээ 37.570м*15.6м зоорьгүй 2 давхар, Эмгэг анатомийн хэсэг Г блок тэнхлэгээрээ 18.6*16.8м зоорьгүй 1 давхар, хүчилтөрөгчийн хэсэг Д лок тэнхлэгээрээ 6.6*4.2м зоорьгүй 1 давхар, Дэд өртөөний хэсэг Е блок тэнхлэгээрээ 10.7м*6.7м зоорьгүй 1 давхар, Дизель генераторын хэсэг Ж блок тэнхлэгээрээ 7.5м*35м зоорьгүй 1 давхар, Уурын зуухны хэсэг И блок тэнхлэгээрээ 16.5м*8.0м зоорьгүй 1 давхар барилга	25,213,363,531.00	2023.12.14	ББАОКД-2023/68
			28,702,415,520.00		
НИЙТ ДҮН			(хорин найман тэрбум долоон зуун хоёр сая дөрвөн зуун арван таван мянга таван зуун хорин төгрөг)		